



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2009 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 01/35

Улаанбаатар хот

Хүн амын амьжиргааны 2009 оны доод түвшинг тогтоох, аргачлалд өөрчлөлт оруулах тухай

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг: “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох аргачлал”-ын 3.1-д “Монгол хүний хүнсний хоногийн (нэг хүнд ногдохоор) илчлэгийн хэмжээ 2100 ккал” гэснийг “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон монгол хүний хүнсний хоногийн (нэг хүнд ногдох) илчлэгийн хэмжээ” гэж өөрчилсүгэй.

Хоёр: “Хүн амын амьжиргааны 2009 оны доод түвшин”-ий хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталж 2009 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлсүгэй.

Гурав: Шинэчлэн баталсан “Хүн амын амьжиргааны доод түвшин”-ий хэмжээг холбогдох байгууллагад албан ёсоор мэдэгдэж, нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Ч.Дагвадорж/-т даалгасугай.



ДАРГА

С.МЭНДСАЙХАН

1400129

Үндэсний статистикийн хорооны даргын
2009 оны 3 сарын 25-ны өдрийн
01/35 тоот тушаалын хавсралт



ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН, БҮС НУТГААР

Бүс нутаг	Хамрагдах аймаг	Амьжиргааны доод түвшин, төг
1. Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	96100
2. Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	90600
3. Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул	91200
4. Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	86300
5. Улаанбаатар	1. Улаанбаатар	101100